

НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР ОНӨААТҮГ

“НИЙСЛЭЛИЙН 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ”-ИЙН  
2023 ОНЫ 3 ДУГААР УЛИРАЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2023 оны 08 дугаар сарын 23-ны өдөр

Улаанбаатар хот

Маягт 4

№	Бодлогын зорилго, арга хэмжээ	Төсөв /сая төг/		Үр шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин		Хэрэгжилт	Хүрсэн буюу гүйцэтгэлийн	Тайлбар (Хүрээгүй бол шалтгаан нөхцөлийн тайлбар)
		Төсөв лөсөн	Гүйцэтгэл		Он	Түвшин	Он	Түвшин			
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Зорилго 4. Инновацад тулгуурласан, өрсөлдөх чадвартай үйлдвэрлэл, үйлчилгээ, хөрөнгө оруулалт, оюуны бөөгнөрлийг дэмжиж, бүтээлч, бие даасан, тогтвортой эдийн засагтай хот болох суурийг бүрдүүлнэ.											
1.	4.1.3. Төсвийн хөрөнгийг эдийн засаг, нийгмийн хөгжилд чиглүүлсэн, үр ашигтай, хариуцлагатай төлөвлөж, сахилга батыг сайжруулсан байна.										
1.1	Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем	-	-	тоо	2020	0	2025	1	Нийслэл хотод хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын ажлыг төлөвлөх, зохион байгуулах, хяналт тавих чиг үүргийн хүрээнд хөтөлж буй цахим системүүд, тэдгээрийн уялдаа холбоо, ашиглалт, тайлан мэдээний чанарт хяналт шалгалт хийж, үнэлэлт дүгнэлт өгөх, хөрөнгө оруулалтын ажлын ил тод байдлыг сайжруулах, бодит өгөгдөл бүхий мэдээллийг солилцох, мэдээллийн технологид суурилсан хяналтыг хэрэгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулж танилцуулах зорилгоор 2021.10.04-2021.10.15-ны өдрүүдэд ажлын хэсэг байгуулж ажилласан. Ажлын хэсэг нь нийслэлийн хэмжээнд хөрөнгө оруулалтын ажлыг санхүүжилтийн эх үүсвэр бүрээр төлөвлөлтийн үе шатнаас өмчид бүртгэх хүртэлх үе шатыг хүртэл бүрэн хамруулсан	100%	

									<p>цахим систем байхгүй байна. Хөрөнгө оруулалтын ажил нь зохион байгуулалтын хувьд оролцогч, шат дамжлага олонтой томоохон зохион байгуулалтын ажил тул цаг хугацааны хоцрогдолгүй, чанартай мэдээ тайлан үүсгэх, нутгийн захиргааны байгууллагуудын мэдээллийн солилцоо, уялдааг хангах, оновчтой, үр өгөөжтэй төлөвлөлт хийх, холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавих, үнэлэх боломжийг бүрдүүлсэн мөн ажил гүйцэтгэгч аж ахуйн нэгж, иргэд олон нийтийг мэдээллээр хангах ухаалаг систем бий болгох хэрэгцээ шаардлага тулгарч байгааг тодорхойлж гаргасан.</p> <p>Манай газарт ашиглагдаж буй Investpro дотоод мэдээллийн системд эрх шилжилт, зөвлөмж, хэрэглэгчийн удирдлага, файлын удирдлага, системийн лог, тохируулга, нэгж, барилга угсралт зэрэг цэсүүдэд тухай бүр засварлалт болон хөгжүүлэлт хийж байна. Мөн Appstore, playstore-т application байршуулан инженерүүд ашиглахад бэлэн болсон.</p> <p>Нийслэлийн Засаг даргаас “нэг систем ашиглах” гэсэн үүрэг даалгаврийн дагуу нийслэлд захиалагчийн хяналт хийдэг байгууллагуудын холбогдох эрхийг нээж, application болон системд хөгжүүлэх шаардлагатай алдаа, зарим нэг системийн доголдлыг засуулах нэмэлт хөгжүүлэлтийн явцын гэрээ хийгдэхэд бэлэн болсон байна</p>		
<p>Зорилго 9. Орон зайн оновчтой төлөвлөлтийн хүрээнд хотын төвлөрлийг задалж орон сууц, дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэн, хот байгуулалтын үйл ажиллагаанд ухаалаг технологийн шинэчлэл хийнэ.</p>											
2.	9.6.2. Дундын бүсийн гэр хороололд хэсэгчилсэн инженерийн хангамжийг нэвтрүүлэх “Дэд бүтцийн төв” төслийг хэрэгжүүлнэ.										

2.1	Дэд бүтцийн төв						<p>*СХД-ийн 4, ХУД-ийн 9, БЗД-ийн 23 дугаар хорооны нутаг дэвсгэрт гэр хорооллын дундын бүсэд хэсэгчилсэн инженерийн хангамжийг нэвтрүүлэх Дэд бүтцийн төвийн ажлын зураг төсөл боловсруулах ажлын гэрээг Эм Эс Эл ХХК-тай байгуулсан. СХД, БЗД, ХУД-ийн дэд бүтцийн төвийн загвар зураг батлагдсан. Гадна шугам сүлжээний ажлын зураг хангагч байгууллагуудтай зөвшилцсөн. Барилгын хөгжлийн төвд магадлал дээр дүгнэлт баталгаажих шатандаа хэрэгжиж байна. Зураг төсвийн 3 ажлын дундаж гүйцэтгэл 95%-тай байна.</p>	95%	
-----	-----------------------	--	--	--	--	--	-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	-----	--